

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААГ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ӨӨРЧЛӨХ БОЛОМЖ

POSSIBILITIES FOR STRUCTURAL AND ORGANIZATIONAL REFORM OF THE ENFORCEMENT OF CIVIL COURT DECISIONS



С.Бямба-Эрдэнэ

*Их засаг Олон Улсын их сургуулийн докторант,
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч*

Товч утга: Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байгаа хариуцагчийг үйлдэл нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж, нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх үндэслэл болдог. Шүүгчийн гаргасан албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг нэхэмжлэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлж, хүсэлт гаргаснаар албадан гүйцэтгэх ажиллагаа эхэлж, шүүхийн шийдвэр биелэгдэх хүртэл үргэлжилдэг билээ. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах арга замыг тасралтгүй эрэлхийлэх нь чухал байдаг. Энэхүү өгүүлэлээрээ дамжуулан уншигч та бүхэндээ иргэний хэргийн шийдвэр ажиллагааг бүтэц, нэгжийн хувьд өөрчлөх боломжийн талаар танилцуулна.

Түлхүүр үг: Шүүх, албадан гүйцэтгэх, гүйцэтгэх хуудас, хариуцагч, нэхэмжлэгч.

Abstract: When a defendant fails to voluntarily comply with a court decision that has entered into legal force, such inaction becomes the basis for enforcing the decision and restoring the claimant's violated rights. Once the judge issues an enforcement order and a writ of execution, the claimant may submit them to the Court Decision Enforcement Agency along with a request to initiate enforcement proceedings. This enforcement process continues until the court decision is fully executed. It is essential to continuously seek ways to improve the enforcement of civil court decisions. Through this article, we aim to introduce

our readers to potential structural and organizational reforms that could enhance the enforcement process of civil cases.

Key words: Court, Compulsory enforcement, Enforcement order, Defendant, Plaintiff.

ҮНДСЭН ХЭСЭГ

УИХ-аас 2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баталж, уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 16 жилийн хугацаанд гүйцэтгэх хуудасны бодит биелэлт хамгийн дээд өсөлтөө 2008 онд 68.5 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 2009 онд 78.54 хувьд хүрч өндөр өсөлтийг тус тус үзүүлсэн байдаг.

Харин УИХ-аас 2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд 8 жилийн хугацаа өнгөрсөн. Гэвч иргэний хэргийн гүйцэтгэх хуудасны бодит биелэлт хамгийн дээд өсөлтөө 2023 онд 58.2 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 2024 онд 32.43 хувьд тус тус хүрч туйлын хангалтгүй өсөлтийг үзүүлсэн юм.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн хүрээнд дараах 3 хуулийн төсөл бичигдээд байна (төсөл, 2025). Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ нь 7 бүлэг, 42 зүйлтэй (төсөл, 2025).

2. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, 15 бүлэг, 139 зүйлтэй (төсөл, 2025).

3. Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл /12 бүлэг, 153 зүйлтэй./ тус тус бичигдэж, хуулийн төслүүдэд нээлттэй санал авч эхлээд байна (төсөл, 2025).

Бид дээрх хуулийн төслүүдээс зөвхөн иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд хамаарах зарим зүйл, заалтын талаар судалгааны ажилдаа нийцүүлж бичсэн болно. Тухайлбал,

Бүтэц, удирдлага, зохион байгуулалтын талаар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын

тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр **эрүүгийн болон зөрчлийн** хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт зааснаар “**Иргэний шийдвэр гүйцэтгэх алба** нь энэ хуулийн 4.1-д заасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа алба байх бөгөөд хуулийн хүчин төгөлдөр **иргэний болон захиргааны** хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага байна.” гэж, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяанд байна” гэж тус тус заасан. Дээрх заалтууд нь яг одоо ШШГЕГ-аас иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж байгаа тогтолцоог хэвээр үлдээх агуулгатай байна (төсөл, 2025).

Мөн хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.10 дэх хэсэгт зааснаар “Иргэний шийдвэр гүйцэтгэгч, алба хаагч Төрийн албаны тухай хуульд заасан цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал авна” гэж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсанаас бусад алба хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ” гэж зааснаас харахад иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дарга, шийдвэр гүйцэтгэгч нар цэргийн цол хэрэглэхгүй, энгийнээр ажиллах талаар бичигдсэн (Төсөл, 2025).

Мөн хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 25.2-т заасан цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хууль тогтоомж иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дарга, иргэний шийдвэр гүйцэтгэгч, алба хаагчид хамаарахгүй бөгөөд Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу урамшуулал, Төрийн албаны тухай хуульд заасан цалин, хөлсийг авч, нийгмийн баталгаагаар хангагдана” гэж мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажллагаа хариуцсанаас бусад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна” гэжээ (төсөл, 2025). Үүнээс харахад иргэний

шийдвэр албаны дарга болон шийдвэр гүйцэтгэгч нар нэгэнт эрт тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авах боломжгүй байхаар төсөлд туссан тул цэргийн цол хэрэглэдэг байгууллагад харьяалагдах шаардлага байхгүй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг бууруулах чиглэл, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн туршлагаас харахад: Учир нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын хувьд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг тус бүрд нь хариуцаж ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн сайн туршлага байна. Тухайлбал,

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ХӨТЯЭХ нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн ялтан, этгээдүүдэд хяналт тавихдаа 2021 оноос эхлэн нэг шийдвэр гүйцэтгэгчид нэг дүүргийн нэг ялаар шийтгэгдсэн бүх ялтанд хяналт тавиулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж байна. Жишээ нь:

1. Баянзүрх дүүрэгт оршин суудаг зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн бүх ялтанд нэг шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих,
2. Сүхбаатар дүүрэгт оршин суудаг үүрэг хүлээлгэж, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн этгээдэд нэг шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих
3. Чингэлтэй дүүрэгт оршин суудаг торгох ял шийтгэгдсэн бүх ялтанд нэг шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих,
4. Сонгинохайрхан дүүрэгт оршин суудаг нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэгдсэн бүх ялтанд нэг шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих гэх мэт ажил үүргийн хуваарилалтыг маш сайн хийж чадсан.

ИХШГА-г шуурхай тасралтгүй зохион байгууллахад тодорхой төрлийн хэрэг маргааныг дагнан хэрэгжүүлэх нэгж, шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зөв хийснээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой. Тухайлбал,

1. Хууль заасан иргэний хэргийн 8 төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дагнан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч,

2. Хууль заасан захиргааны хэргийн 4 төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дагнан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэгч,

3. Хуульд заасан зөрчлийн хэргийн 7 төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 5 төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлэх, /албадан сургалтанд хамруулах, торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн гүйцэтгэх хуудас, хохирол нөхөн төлбөр гаргуулах, хөрөнгө, орлогыг хураах тухай шийдвэр/

Шийдвэр гүйцэтгэх албыг бие даасан агентлаг болгох боломж: Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайд /цаашид "сайд"гэх/-ын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна” гэж заасан байдаг (эмхэтгэл, 2004). Хэрвээ Шийдвэр гүйцэтгэх албыг бие даасан засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон бүтэц, орон тоог шинэчлэн баталвал:

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж оролцож байгаа албан тушаалтнуудыг 1-7 хүртэл тоогоор дугаарлаж, хамгийн сүүлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байгаа шийдвэр гүйцэтгэгчийг бичлээ.

1. Монгол Улсын Ерөнхий сайд, шадар сайд
2. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд
3. Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, улсын ерөнхий гүйцэтгэгч,
4. Шийдвэр гүйцэтгэх албаны мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга
5. Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах мэргэжилтэн
6. Газар, хэлтсийн дарга
7. Ахлах шийдвэр гүйцэтгэгч
8. Тухайн тойргийн шийдвэр гүйцэтгэгч

Шийдвэр гүйцэтгэх албыг бие даасан агентлаг болгон бүтэц орон тоог шинэчилж чадвал иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 6 субъект оролцохоор харагдаж байгаа юм.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэх. Монголын төр эрх зүйн түүхийн

шинэ болон нэн шинэ үед /1926-1996 онд/ иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх хэрэгжүүлж, шүүгч гаргасан шийдвэрийнхээ биелэлтэнд хяналт тавьж, шийдвэр гүйцэтгэгчийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байсан.

Доктор Я.Батгэрэл “ШШГБ-ын тогтолцоо хаана харьяалагдаж байгаагаас шүүхийн шийдвэрийн биелэлтэнд нөлөө үзүүлнэ гэх үзэл хандлага сүүлийн үед нэлээдгүй яригдаж байгаа бөгөөд иргэний хэргийн болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд Шүүхийн харьяалалд байх нь зүйтэй гэсэн хандлага их байдаг” гэж иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллыг шүүхийн харьяанд байлгахыг дэмжсэн агуулгыг бүтээлдээ тусгасан байна (Я.Батгэрэл, 2024, хууд. 149).

МУ-ын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулалтын хувьд бие даасан байх бөгөөд Улсын дээд шүүхийн аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ” гэж заасан байдаг. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” заасан (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2021).

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шат болохынхоо хувьд шүүхийн шийдвэр бодитой биелэгдсэнээр эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй /төлбөр төлөгч-иргэн эд хөрөнгөгүй байх хугацаандаа нас барах, хуулийн этгээдийн дампуурлыг шүүхээс тогтоох/ нөхцөл байдал тогтоогдсоноор иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгодог. Хэрвээ иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх хэрэгжүүлж эхэлбэл ажиллагаанд хяналт тавьж оролцож байгаа албан тушаалтнуудыг 1-4 хүртэл тоогоор дугаарлаж, хамгийн сүүлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байгаа шийдвэр гүйцэтгэгчийг бичлээ.

1. Ерөнхий шүүгч
2. Шүүгч
3. Ахлах шийдвэр гүйцэтгэгч
4. Шийдвэр гүйцэтгэгч

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн маргааныг хянан шийдвэрлэх шүүгчийн орон тоог бий болгох, шүүх байгуулах боломж: Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” заасан (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2021).

Монгол Улсын Их хурлаас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг шинэчилж тогтоосон бөгөөд тус шинэчилсэн найруулгын 3 дахь хэсэгт “Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх”, 4 дэх хэсэгт “Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх” байгуулах талаар заасан (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2024).

“Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх” 2026 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаагаа явуулж эхлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа билээ (ярилцлага, 2024).

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны шүүх нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд хялбар ажиллагааны шүүх нь орон нутагт үйл ажиллагаа явуулах боломжгүй зөвхөн нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг хариуцахаар хуулинд заасан.

Хялбар ажиллагааны анхан шатны шүүх нь 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 751 дүгээр зүйлийн 751.2.1 дэх хэсэгт зааснаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол”-ыг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2002).

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны дараах бие даасан, албадлагын үе шат байх бөгөөд иргэний 6

шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргах талуудын гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэхгүй” гэж заасныг буруу гэж бодож байна (төсөл, 2025).

Мөн хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь энэ хуулийн 6.2-т заасан шийдвэрээр тогтоогдсон төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор төлбөр гаргуулах, тодорхой үйлдэл хийлгэх, хийлгэхгүй байхад чиглэсэн албадлагын үе шат тул иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа энэ хуульд нийцсэн эсэх талаар талуудын гаргах шуурхай гомдлыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу **шийдвэр гүйцэтгэлийн шүүгч** шуурхай хянан шийдвэрлэнэ” гэж, мөн хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шуурхай гомдлыг ажлын 5 өдрийн дотор аман хуралдаан хийлгүйгээр, зөвхөн гомдол гаргагчаас ирүүлсэн энэ хуулийн 14.3-т заасан нотлох баримт, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэл, бусад баримтад үндэслэн хянаж, бичгээр шийдвэрийг гаргана” гэж тус тус заасан (төсөл, 2025). Хуулийн төслөөс харахад шүүгч ИХШГА-г хянаж, гомдол шийдвэрлэх эрхтэй шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийг төсөлд заасан нь маш оновчтой бөгөөд цаашид ИХШГА-ны бие даасан шүүх байгуулж Иргэний шийдвэр гүйцэтгэх албыг ШШГЕГ-т бус тус шүүхэд харьяалуулах, шийдвэр гүйцэтгэлийн шүүгчээс шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах талаар хуулийн төсөлд тусгах шүүх эрх мэдлийг баталгаажуулах боломжийг бүрдүүлнэ.

Судлаачийн зүгээс иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн маргааныг дагнан шийдвэрлэх тусгайлсан шүүх байгуулж болно гэж бодож байна. Учир нь шүүхийн статистик мэдээнээс харахад Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2010-2024 он, 2025 оны 4-р сарын байдлаар хянан шийдвэрлэсэн хэргийн дотор ШШГТХ-иар /хөрөнгийн үнэлгээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой/ гомдол хянан шийдвэрлэсэн тоо нийт 4,704 байна. Жил бүр тасралтгүй өсөж байгаа энэ дүн буурах төлөв ажиглагдахгүй байна. Бид төлбөр төлөгч-иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагад өргөдөл, хүсэлт, гомдол гаргах, шүүхэд хандах эрхийг хаах эрх байхгүй тул дагнасан шүүх байгуулах боломжтой гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэлийн маргааныг шийдвэрлэх шүүхийн үйл ажиллагааг нэн тэргүүн ээлжинд нийслэлд байгуулах, нийслэлд байгуулагдсан “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шүүх”

нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 3,26 их наяд төгрөгийн 14,541 гүйцэтгэх баримт бичигт хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой (Мэдээлэл, 2025).

ДҮГНЭЛТ

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн шүүхээс гарсан хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрт холбогдуулан албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах замаар нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх бөгөөд хэт олон даргын хяналт дор албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах нь хүндрэл дагуулдаг. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч гэсэн орон тоо байдаггүй бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нь зөрчил, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийг давхар хариуцан ажилладаг нь ачаалал үүсгэдэг байна. Цаашид иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанаас гаргаж, иргэний хэргийн шүүхэд харьяалуулах шаардлагатай гэж үзэж байна.

САНАЛ

1. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй “иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч” гэсэн орон тоог бий болгох,
2. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг иргэний хэргийн шүүхэд шилжүүлэх боломжийг эрэлхийлэх
3. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдлыг хянан шийдвэрлэх шийдвэр гүйцэтгэлийн шүүх байгуулах

Эх сурвалж

Мэдээлэл. (2025). Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Нийслэл Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар/ төвийн 6 дүүргийн хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг.

Төсөл. (2025). Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт "иргэний шийдвэр гүйцэтгэгч" гэж шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа иргэний шийдвэр гүйцэтгэх албаны иргэнийн болон захиргааны шийдвэр. УБ.

төсөл, (2025). <https://mojha.gov.mn/>. [https://mojha.gov.mn/:
https://mojha.gov.mn/-ээс](https://mojha.gov.mn/:https://mojha.gov.mn/-ээс) Гаргасан
эмхэтгэл, Т. м. (2004). Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн
байдлын тухай хууль. Уб: №16.
эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2002). Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх тухай хууль. Уб.
эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2021). Монгол Улсын Шүүхийн тухай хууль.
Уб.
эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2024). Монгол Улсын Шүүх байгуулах тухай
хууль. Уб.
Я.Батгэрэл. (2024). Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх
хууль зүйн хариуцлага. Хууль сахиулахын докторын диссертаци. Уб.
ярилцлага, (2024 оны 12 30). judcouncil. Гаргасан 2024 оны 12 30,
https://judcouncil.mn/site/news_full/14653 :
https://judcouncil.mn/site/news_full/14653